



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2026 оны ээлжит 03 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 03 дугаар хуралдааныг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг тус тус үндэслэн ХХЗХ-ны дарга, орон тооны бус 6 гишүүнийг Монгол улсын Ерөнхий сайдын Захирамжаар томилдог. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2026 оны 11 тоот Захирамжаар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзоригийг чөлөөлөв. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2026 оны 12 тоот Захирамжаар Жалавсүрэнгийн Бат-Эрдэнийг Харилцаа холбооны зохицуулах хорооны даргаар 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 6 жилийн хугацаагаар томилсон.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар /2026-02-13/ "Журам шинэчлэн батлах тухай" танилцуулга (Мэдээлэл харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах журмын төсөл); "Сонгон шалгаруулалт зарлах тухай" танилцуулга, радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөл, тогтоолын төсөл (Булган аймгийн Хутаг-Өндөр, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Онгон, Эрдэнэцагаан, Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөл); ХХЗХ-ны 2025 оны жилийн эцсийн өргөдөл, гомдлын тайлан мэдээлэл танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай дүгнэлт) зэрэг асуудлыг тус тус хэлэлцээд, Зохицуулах хорооны 7 (Тогтоол №24-30, 2026-02-13) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам"-ыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 4417 тоот улсын бүртгэлд хянуулан бүртгүүлж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус хороо нь 2025 оны 06 дугаар сард Үндэсний итгэмжлэлийн төвөөс MNS ISO/IEC 17065 стандартаар итгэмжлүүлэх шалгалтад хамрагдаж, гэрчилгээ авсан болно. Харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах эрх зүйн байдалд дүгнэлт, санал боловсруулах зорилготой Хорооны даргын 2025 оны А/210 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, итгэмжлэлийн нийцлийг хангах, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамтай нийцүүлэх талаар судалгаа хийж ажилласан болно. Ажлын хэсгээс боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, "Мэдээлэл, харилцаа холбооны тоног

төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ын шинэчилсэн төслийг 2025 оны 12 дугаар сард Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, санал зөвлөмжийг тусган олон нийтэд санал авах, эрх ашиг нь хөндөгдөж буй 10 гаруй төрийн байгууллага (ЦХИХХЯ, СХҮТ, Үндэсний итгэмжлэлийн төв), ТББ, хувийн хэвшлийн төлөөллийн уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн санал зөвлөмжийг авч боловсруулсан. ХХЗХ-ны 2026 оны ээлжит 03 дугаар хуралдаанд ажлын хэсгээс боловсруулсан “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ын шинэчилсэн төслийн танилцуулга, эрх ашиг нь хөндөгдсөн төр, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн саналын товчоо, холбогдох “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын төсөл, тогтоолын хавсралт журмын төслийг тус тус хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 02 дугаар 13-ны өдрийн 26 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тогтоол, тогтоолын хавсралтаар “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг шинэчлэн батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам батлах тухай” 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 29 тоот тогтоолыг хүчингүй болгов. “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг шинэчлэн баталснаар Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж (цаашид “тоног төхөөрөмж гэх”)-д баталгаажуулалт, тохирлын үнэлгээг гүйцэтгэх боломж бүрдэж байна. Үүнд: Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал, радио давтамжийн холбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг, тогтоосон шаардлага хангасныг нотлох; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтын хэрэгжилтийг хангах; Тоног төхөөрөмжийг баталгаажуулах, баталгаажсан тоног төхөөрөмжид тохирлын гэрчилгээ олгох, хүчингүй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах; Зах зээлд хуурамч болон стандарт шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүн орж ирэхээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зэрэг болно. Хорооны хуралдаанаар баталсан 2026 оны 24 тоот тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын мэдээллийн нэгдсэн санд хянуулан бүртгүүлэхээр хүргүүлэх, ХЗДХЯ-тай хамтран ажиллахыг РДЗХГ, ЗУХАГ, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д тус тус даалгав. ХХЗХ-ны Даргын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 02/376 албан тоотоор ХЗДХЯ-нд хянуулан бүртгүүлэхээр хүргүүлээд байна.

Харилцаа холбооны зохицуулах хороонд нэр бүхий ААН, хуулийн этгээд нараас Улаанбаатар хотын алслагдмал дүүргүүд болон орон нутгийн иргэдэд мэдээ, мэдээлэл, боловсрол, соёл, урлагийн агуулгатай хөтөлбөрүүдийг хүргэх, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжил, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 12 байршилд радио станц ажиллуулах зөвшөөрлийн хүсэлтийг ирүүлсэн болно. Тус хорооноос ирүүлсэн хүсэлтийг холбогдох бүтцийн нэгж, хуулийн хэлтсээс хамтран судалж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2, 5<sup>1</sup>.1.11 дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт

богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг тус тус үндэслэн "Булган аймгийн Хутаг-Өндөр, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Онгон, Эрдэнэцагаан, Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт"-ийн баримт бичгийн төсөл, сонгон шалгаруулалт зарлах тухай тогтоолын төслийг ажлын хэсгээс тус тус боловсруулсан. Тус хорооны 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит 03 дугаар хуралдаанаар Ажлын хэсгийн боловсруулсан дээрх сонгон шалгаруулалтын талаар танилцуулга, ирүүлсэн хүсэлт, ажлын хэсгийн санал, дүгнэлт болон тогтоолын төсөл, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>, 5<sup>1.1.11</sup> дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт", Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг тус тус үндэслэн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 25 тоот "Сонгон шалгаруулалт зарлах тухай" тогтоолыг баталж шийдвэрлэв. Энэхүү тогтоолд, "Тогтоолын 1 дүгээр заалтад, "Булган аймгийн Хутаг-Өндөр, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Онгон, Эрдэнэцагаан, Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт"-ыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр зарласугай. 2 дугаар заалтад, Энэхүү тогтоолын хавсралтаар "Сонгон шалгаруулалтын баримт бичиг"-ийг баталсугай. 3 дугаар заалтад, Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай." гэжээ. ХХЗХ-ноос 2026 оны 25 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-ноос ХХЗХ-2026 /РДСШ-02/ тоот Сонгон шалгаруулалтыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл хугацаагаар зарласан болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар "ХХЗХ-ны 2025 оны жилийн эцсийн өргөдөл, гомдлын тайлан мэдээлэл танилцуулга" мэдээллийг сонсов.

Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 03 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.8</sup> дахь заалтыг тус тус үндэслэн 2026 оны 02 дугаар 13-ны өдрийн 26 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Виртуал линк

ХХК: Өмнөговь аймгийн Даланзадгад, Дундговь аймгийн Сайнцагаан сумны нутаг дэвсгэрт Утасгүй интернэтийн үйлчилгээнд “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах”; Ашиглах радио давтамжийн зурвас: 5530-5570МГц) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 02 дугаар 13-ны өдрийн 27 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 3 хуулийн этгээдэд 3 тусгай зөвшөөрлийг (Бум эх цацрал ХХК, Төгс элбэг ноёд ХХК, Сэрхийн туяа ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 02 дугаар 13-ны өдрийн 28 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Согно телеком ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ байгуулах түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” 16900002 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 02 дугаар 13-ны өдрийн 29 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээд, 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг (Стандарт, хэмжил зүйн газар-1-800-2525; Үндэсний хөрөнгө оруулалтын банк ХХК-1-800-1188) 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 02 дугаар 13-ны өдрийн 30 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд олгосон 5 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2026-02-28